Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өөрчлөлт	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Хувь
А	1	2	3	4	5	6
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	287,764.2	9.4%	357,004.7	12.1%	69,240.5	24.1%
Мөнгөн хөрөнгө	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Авлага	4.6	0.0%	4.6	0.0%	-	0.0%
Урьдчилгаа	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Бараа материал	287,759.6	9.4%	357,000.1	12.1%	69,240.5	24.1%
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,760,051.5	90.6%	2,602,439.8	87.9%	(157,611.7)	-5.7%
Үндсэн хөрөнгө	5,125,794.9	168.2%	5,195,382.0	175.6%	69,587.1	1.4%
Хуримтлагдсан элэгдэл	(2,365,743.4)	-77.6%	(2,592,942.2)	-87.6%	(227,198.8)	9.6%
Нийт хөрөнгө	3,047,815.7	100.0%	2,959,444.5	100.0%	(88,371.2)	-2.9%
Өр төлбөр	-	0.0%	5,378.1	0.2%	5,378.1	0.0%
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,047,815.7	100.0%	2,954,066.4	99.8%	(93,749.3)	-3.1%
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,047,815.7	100.0%	2,959,444.5	100.0%	(88,371.2)	-2.9%

Авлагын дансны үлдэгдэл болох 4.6 мянган төгрөг нь өмнөх оноос үүссэн байгууллагаас авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 357,000 мянган төгрөг болж 69,240.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн худалдан авалтаар 366,269.7 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, хандив тусламжаар 5600.0 мянган төгрөгийн аж ахуйн материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, бичиг хэргийн материалаас 6,024.0 мянга, аж ахуйн материал данснаас 42,916.2 мянга, барилгын засварын материалаас 58,742.7 мянга, түлш шатах тослох материал данснаас 7,680.5 мянга, тусгай зориулалтын материалаас 125,955.1 мянга, эм боох материалаас 697.3 мянга, хүнсний материалаас 59,993.5 мянга, бусад хангамжийн материал данснаас 620.0 мянга, нийт 302,629.2 мянган төгрөгийг зарцуулсан нь голлох нөлөө үзүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,195,382.0 мянган төгрөг болж 69,587.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн худалдан авалтаар 78,820.0 мянга, Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар 8,696.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, төгсөлтийн хандиваар 25,550.0 мянган төгрөгийг хөрөнгийг хүлээн авч, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 26-ний өдрийн 833 дугаар тогтоолоор 43,478.9 мянган төгрөгийн балансын үнэ бүхий

тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг данснаас хасах шийдвэр гарсны дагуу акталж, бүртгэлээс хассан байна.

Өглөгийн дансны үлдэгдэл 5,378.1 мянган төгрөг болж өмнөх оноос өссөн нь ажилчидтай холбоотой нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 47.4 мянга, хувь хүний орлогын албан татварын өглөг 4,986.3 мянга, газрын төлбөрийн өглөг 344.4 мянган төгрөгийн өглөг тус тус үүссэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,954,066.4 мянган төгрөг болж 93,749.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 93,749.3 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,031,247.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,031,247.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 356,823.3 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлыг 204,007.9 мянга, нормативд зардлыг 16,081.5 мянга, бараа үйлчилгээний зардлыг 103,940.3 мянган төгрөгөөр өсгөж, төгрөгөөр өсгөж, хангамж, бараа материалын зардлыг 32,789.8 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 271,970.0 мянга, томилолт, зочны зардлыг 2,989.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 4,462.5 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 23,243.6 мянган төгрөгөөр бууруулж 3,754,428.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь Баянхонгор аймгийн Политехник коллеж нь Монгол улсын Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолоор албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 3,217,240.2 мянга, орон нутгийн төсвөөс 537,188.0 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 36,418.5 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 3,093,747.3 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 657,526.5 мянга, орон нутгийн төсөвт 3,154.5 мянга, нэмэлт санхүүжилтээс 4,768.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,093,747.3 мянган төгрөг буюу нийт батлагдсан төсвийн 82.4 хувийг зарцуулсан байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлаас 563,617.4 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх

шимтгэл 45,762.5 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3,154.5 мянга, хангамж, бараа материалын зардал 7,243.6 мянга, нормативд зардал 33,388.7 мянга, эд хогшил урсгал засварын зардал 341.5 мянга, томилолтын зардал 369.8 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 15.8 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 1,471.1 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 235.4 мянган төгрөгийг хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71804 Мэргэжлийн боловсрол	3,754,428.20	3,093,747.20	660,681.00	82.4%
1	80101 Үндсэн үйл ажиллагаа	3,001,826.40	2,377,915.10	623,911.30	79.2%
2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	124,408.50	124,173.10	235.40	99.8%
3	81806 Дотуур байрны үйлчилгээ	91,005.30	57,625.50	33,379.80	63.3%
2	71702 Соёл урлаг	537,188.00	534,033.50	3,154.50	99.4%
1	80112 Нийтлэг үйлчилгээ	537,188.00	534,033.50	3,154.50	99.4%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 36,418.5 мянга, төгрөгийн орлого бүрдүүлж, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 2,990.6 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 28,659.2 мянган төгрөгийг зарцуулж, 4,768.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 91,005.3 мянган төгрөгийн дотуур байрны хүүхдийн хоол хүнсний материал нийлүүлэх, хичээл үйлдвэрлэлийн дадлагын материал нийлүүлэх 133,355.6 мянга, нийт 224,360.9 мянган төгрөгийн төгрөгийн материал нийлүүлэх тендер шалгаруулахаар төлөвлөсөн байна.

Тус байгууллага нь дотуур байрны хүүхдийн хоол хүнс нийлүүлэх тендерт шалгарсан Далай ээж ХХК-тай 29,940.0 мянга, Софтвишн ХХК-тай 17,690.0 мянга, Цастын салхи ХХК-тай 16,529.4 мянга, иргэн Данзанжанцантай 11,453.0 мянга нийт 75,612.4 мянган төгрөгийн гэрээ байгуулж, хичээл үйлдвэрлэлийн дадлагын материал нийлүүлэх тендерт шалгарсан Болд суварга ХХК-тай 109,783.0 мянган төгрөгийн гэрээг тус тус байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Политехник коллеж нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Политехник коллежийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 222 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,769,100.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 27,691.0 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 19,383.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2023 оны байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 3,154.5 мянга буюу 0.6 хувь, бичиг хэргийн зардлыг 12.1 мянга буюу 0,3 хувиар нийт 3,166.6 мянган төгрөгийн хэмнэлт бий болгосон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих 6.4.5¹-д заасан цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 32,113.7 мянган төгрөгийн 4 гүйлгээ, орлогын 28,660.0 мянган төгрөгийн 1 гүйлгээг, хуулийн 6.4.3²-т заасан 224,360.9 мянган төгрөгийн тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээллийг байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.5-д заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж аудитаар 787.4 мянган төгрөгийн 2 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгах 500.8 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 286.6 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоосныг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 144 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	286.6	1	286.6	100%
Албан шаардлага	1	500.8	1	500.8	100%
Зөвлөмж					
Нийт дүн	2	787.4	2	787.4	100%

¹ Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”

² тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас ирүүлсэн судалгаагаар 862 м² бүхий газар бүртгэлтэй бөгөөд тухайн байгууллагын данс бүртгэлд байхгүй байгаа талаар тодруулахад 2011 оноос хойш үүссэн газрын маргаантай асуудал байгаа бөгөөд хууль хяналтын байгууллагад шийдвэрлүүлэхээр хандсан гэсэн тайлбарыг өгсөн. Дараагийн аудитаар тус газрын маргаан шийдвэрлэгдсэн эсэхийг авч үзэх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 81,294.9 мянган төгрөгийн 5 алдаа³ илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

1. Үр дүнгийн тайланд байгууллагын ажилчдын амралтын цалингийн зөрүү болох 67,220.8 мянган төгрөгийн цалингийн бичилтийг орхигдуулсан байгаа нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, мөн үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

2. Тус байгууллагын ажилчдын 7,8 сарын амралтын цалин болох 67,220.8 мянган төгрөгөөс суутгасан ХХОАТ-ыг цалин хөлс түүнтэй адилтгах орлогоос суутган төлөгчийн тайланд мэдээлээгүй, суутгасан ХХОАТ болох 4,986.3 мянган төгрөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байгаа нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, мөн үнэлгээ ба хуваарилалт, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

3. Боловсролын ерөнхий газраас үнэ төлбөргүй ирүүлсэн 8696.0 мянган төгрөгийн өртөг бүхий үндсэн хөрөнгийг хандиваар хүлээн авсан ангиллаар бүртгэсэн байгаа нь УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, мөн ангилал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

4. Тайлант хугацааны газрын төлбөрийн үлдэгдлийг тулгахад 2020-2023 онуудад төлөгдөөгүй 344.4 төгрөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байгаа нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

5. Нягтлан бодогч нь 6 дугаар сард 1 ажилтны цагийн үнэлгээний цалингийн нийгмийн даатгалд мэдээлэхдээ жирэмсэн амаржсан буюу 17 код дээр мэдээлж, даатгуулагчаас төлөх 47.4 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг мэдээлээгүй байгаа нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, мөн үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 351,590.3 мянган төгрөгийн 5 зөрчил⁴ илэрснээс 5,898.2 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 345,692.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 5,898.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 13,485.5 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

³ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

⁴ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Байгууллагын даргын 2023.12.28-ны өдрийн Б/105 дугаар тушаалаар албан хаагчдад улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тооцож олгосон бөгөөд 2023.12.15-ны өдрийн Б/93 дугаар тушаалаар нэр бүхий 21 албан хаагчид жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг нь харгалзан 20 хувиар, мөн 2023.12.15-ны Б/101 дугаар тушаалаар захирлын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн нэр бүхий 6 ажилтанд үндсэн цалингийн 10 хувьтай тэнцэх нэг удаагийн мөнгөн урамшуулал, нийт 5,048.6 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байгаа байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1⁵, Засгийн газрын 2019 оны “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох” 5 дугаар тогтоолын 4.9⁶-д заасан заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шийдвэр гаргасан холбогдох буруутай албан тушаалтнуудаар буцаан төлүүлж, төлбөрийн актыг тогтоов.

5.1.2 Тус байгууллагын дарга 1,12 дугаар саруудад төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болох 433.2 мянган төгрөгийг давхардуулан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1⁷, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 4 дүгээр хавсралтад заасан 3⁸ дахь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох буруутай албан тушаалтнуудаар буцаан төлүүлж, төлбөрийн актыг тогтоов.

5.1.3 Тус байгууллагын 1 ажилтны амралтын цалинг нийгмийн даатгалд мэдээлэхдээ 416.4 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4⁹, Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1¹⁰, 32 дугаар зүйлийн 32.2.2¹¹ -д заасан заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын санд мэдээлээгүй 416.4 мянган төгрөгийн цалинг нөхөн мэдээлэх төлбөрийн актыг тогтоов.

⁵ Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

⁶ Төрийн өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно

⁷ Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

⁸ Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно.

⁹ үнэн зөв байх

¹⁰ Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө

¹¹ Орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх

5.2 Албан шаардлага

5.2.1 Тайлант хугацааны урсгал засварын зардлаас зарцуулсан 60,557.5 мянган төгрөгийн барилгын засварыг байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3¹², Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.13¹³ дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын урсгал засвартай холбоотой тооцоолол болон байгууллагын өмч хөрөнгийн өөрчлөлттэй холбоотой шийдвэрт өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.2.2 Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих 6.4.5 -д заасан цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 32,113.7 мянган төгрөгийн 4 гүйлгээ, орлогын 28,660.0 мянган төгрөгийн 1 гүйлгээг, хуулийн 6.4.3 -т заасан 224,360.9 мянган төгрөгийн тендэрт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.3¹⁴, 6.4.5¹⁵ дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.5-д заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
						Тоо	Дүн	Тоо	Дүн	
Үр дүнгийн тайланд байгууллагын ажилчдын амралтын цалингийн зөрүү болох 67,220.8 мянган төгрөгийн цалингийн бичилтийг орхигдуулсан байна.	1	67,220.8	1	67,220.8			1	67,220.8		
Тус байгууллагын ажилчдын 7,8 сарын амралтын цалин болох 67,220.8 мянган төгрөгөөс суутгасан ХХОАТ-ыг цалин хөлс түүнтэй адилтгах орлогоос суутган төлөгчийн тайланд мэдээлээгүй, суутгасан ХХОАТ болох 4,986.3 мянган төгрөгийг	1	4,986.3	1	4,986.3			1	4,986.3		

¹² Худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх

¹³ Өмч хамгаалах зөвлөл нь хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, сэлбэг эд ангийг солих, барилга байгууламжийн их засвар хийх тохиолдолд батлагдсан норм норматив, стандартыг мөрдүүлэх, барилгын болон техникийн хувийн хэрэгт нь баяжилт хийлгэх зэргээр хяналт тавьж ажиллана

¹⁴ тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендэрт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендэрт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;

¹⁵ Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ"

Баянхонгор аймгийн Политехник коллежийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй									
Боловсролын ерөнхий газраас үнэ төлбөргүй ирүүлсэн 8,696.0 мянган төгрөгийн өртөг бүхий үндсэн хөрөнгийг хандиваар хүлээн авсан ангиллаар бүртгэсэн байна.	1	8,696.0			1	8,696.0	1	8,696.0	
Тайлант хугацааны газрын төлбөрийн үлдэгдлийг тулгахад 2020-2023 онуудад төлөгдөөгүй 344.4 мянган төгрөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй	1	344.4	1	344.4			1	344.4	
Нягтлан бодогч нь 6 дугаар сард 1 ажилтны цагийн үнэлгээний цалинг нийгмийн даатгалд мэдээлэхдээ жирэмсэн амаржсан буюу 17 код дээр мэдээлж, даатгуулагчаас төлөх 47.4 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг мэдээлээгүй байна.	1	47.4	1	47.4			1	47.4	
Дүн	5	81,294.9	4	72,598.9	1	8,696.0	5	81,294.9	

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын даргын 2023.12.28-ны өдрийн Б/105 дугаар тушаалаар албан хаагчдад улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тооцож олгосон бөгөөд 2023.12.15-ны өдрийн Б/93 дугаар тушаалаар нэр бүхий 21 албан хаагчид жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг нь харгалзан 20 хувиар, мөн 2023.12.15-ны Б/101 дугаар тушаалаар захирлын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн нэр бүхий 6 ажилтанд үндсэн цалингийн 10 хувьтай тэнцэх нэг удаагийн мөнгөн урамшуулал, нийт 5048.6 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон.	1	5,048.6	1	5,048.6				
Байгууллагын дарга 1,12 дугаар саруудад төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болох 433206 төгрөгийг давхардуулан авсан байна.	1	433.2	1	433.2				
Тус байгууллагын 1 ажилтны амралтын цалинг нийгмийн даатгалд мэдээлэхдээ 416.4 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.	1	416.4	1	416.4				
Тайлант хугацааны урсгал засварын зардлаас зарцуулсан 60,557.5 мянган төгрөгийн барилгын засварыг байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргаагүй байна.	1	60,557.5			1	60,557.5		
Нийт дүн	4	66,455.7	3	5,898.2	1	60,557.5		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 32,113.7 мянган төгрөгийн 4 гүйлгээ, орлогын 28660.0 мянган төгрөгийн 1 гүйлгээг, хуулийн 6.4.3-т заасан 224,360.9 мянган төгрөгийн тендэрт шалгарсан болон шалгараагүй	1	285,134.6			1	285,134.6		

Баянхонгор аймгийн Политехник коллежийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

оролцогчийн талаарх мэдээллийг байршуулаагүй байна.								
Дүн	1	285,134.6			1	285,134.6		

-----oO-----